



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 5/926

Улаанбаатар хот

Ч.Алтанцэцэгийг ажлаас чөлөөлж, нэг удаагийн  
буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.7, 271<sup>1</sup>.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч ахлах Чогдонгийн Алтанцэцэгийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ч.Алтанцэцэгт төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 24 595 670 /хорин дөрвөн сая таван зуун ерэн таван мянга зургаан зуун далан/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Ч.Алтанцэцэгийн гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авах, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар /Б.Өнөболд/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 2957